

ТАНИЛЦУУЛГА

Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улс "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай" 1963 оны Токиогийн конвенцид 1990 оны 07 дугаар сарын 24-ний өдөр нэгдэн орсон.

Канад Улсын Монреал хотноо 2014 онд зохион байгуулсан Нисэхийн аюулгүй байдлын Дипломат бага хурлаас нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, өмч хөрөнгө, хөлгийн бүхээг дэх хэвийн журам, дэглэмд аюул учруулж болзошгүй агаарын хөлгийн бүхээг дэх хяналтгүй зан төлвийг хязгаарлахад харилцан туслалцаа үзүүлэх олон улсын хэм хэмжээг бэхжүүлэх зорилгоор "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц"-ын нэмэлт протоколыг баталсан.

"Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол" нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд нийт 36 улс гарын үсэг зурж, 15 улс соёрхон баталж, 20 улс нэгдэн орж, 3 улс хүлээн зөвшөөрсөн байна.

"Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай" 1963 оны Токиогийн конвенцид агаарын хөлгийн бүхээгт гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд уг агаарын хөлгийг бүртгэсэн улсад хэргийн харьяалал хэрэгжүүлэх эрхийг олгодог байсныг дээрх нэмэлт протоколд агаарын хөлгийн бүхээгт сэжигтэн этгээд байх үед тухайн агаарын хөлгийг буулгасан улс болон тээвэрлэгч улс хэргийн харьяаллыг мөн хэрэгжүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан. Мөн гэмт хэргийн харьяаллыг илүү өргөжүүлсэн бөгөөд хэв журам зөрчих, гэм хорыг арилгахтай холбоотой нөхөн төлбөрийн зохицуулалтыг нэмсэн.

Монгол Улс "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц"-ын оролцогч улсын хувьд агаарын харилцаа өргөжин хөгжиж, агаарын тээврийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед агаарын хөлгийн бүхээгт үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах иргэний нисэхийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах шаардлагатай.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт "Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана" гэж заасны дагуу "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.